



## Нэг. НИЙСЛЭЛИЙН “УЛААНБААТАР” ЧУУЛГЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ ТҮҮХЭН ЗАМНАЛ

Нийслэлийн “Улаанбаатар” чуулга нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2006 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 487 дугаар захирамжаар Нийслэлийн “Улаанбаатар” чуулга нь:

1. Дарга Ц.Төвшинтөгс
2. Даргын туслах О.Болормаа
3. Маркетингийн албаны дарга П.Урнаа
4. Хүний нөөц Б.Баяржаргал
5. Нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг
6. Найруулагч Болд
7. Нярав Батсуурь

8. Жолооч Ж.Энхбат гэсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй соёлын төв өргөөний А хэсэгт байгуулагдаж байсан.

Нийслэлийн “Улаанбаатар” чуулга нь Нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, иргэдийн уран сайхны боловсролыг дээшлүүлэх Улаанбаатар хотыг гадаад дотоодод сурталчилах зорилгоор үүсгэн байгуулагдсан Улаанбаатар хотын харъяа мэргэжлийн урлагийн байгууллага юм.

2006 оны 10-р сарын 10-нд Ардын хөгжмийн “Гэрэгэ” хамтлаг, джаз хөгжмийн “Пауз” хамтлаг, мэргэжлийн өндөр зэрэглэлийн дуучид, хөөмэйч, уран нугараач, бүжиг дэглээч, бүжигчид, багш, удирдаач зэрэг 30 гаруй уран бүтээлчид уран бүтээлээ туурвиж захиргаа санхүү, маркетингийн алба, уран бүтээлийн анги гэсэн 3 нэгжтэйгээр тулгын чулуугаа тавьж байсан. 2009 онд поп морин хуурын чуулгатай болж өөрчлөгдсөн.

Байгуулагдсан цагаас хойш чуулгын даргаар МУГЖ Ц.Төвшинтөгс ажиллаж байгаа билээ.

### **Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын дарга МУГЖ Ц.Төвшинтөгс:**

Итали улсад дуулаачийн мэргэжил эзэмшсэн ба тэрээр Монгол үзэгчдийн хайртай уран бүтээлчдийн нэг бөгөөд Монголд тавигдсан дэлхийн хэмжээний томоохон сонгодог дууриуудад болон олон дүрүүдийг бүтээсэн Монголын урлагийн томоохон зүтгэлтэний нэг мөн.

Түүний гавъяа шагналуудаас дурьдвал:

1975-1985 онд Хэнтий аймгийн 10 жилийн дунд сургууль

1987-1992 онд СУИС-д суралцаж дуулаачийн мэргэжил эзэмшсэн

1996 онд Итали улсын Триест хотод мэргэжил дээшлүүлсэн

2003-2005 онд МУЗГХА Удирдлагийн академийн Нийгмийн удирдлагийн менежер

2005-2007 онд СУИС-ийн урлаг судлалын магистр

2007 онд “Монголжингоо” дээд сургуулийн дэд профессор

2007 онд докторантур

1992-2007 УДБЭТеатр гоцлол дуучин

2006 оноос СУИС-ийн Дуулах ур зүй, уран чадвар, дуурийн тавилын багш,



2006-оноос уран сайхны удирдагч, Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын даргаар ажиллаж байна.

“Учиртай гурван толгой” дүүргийн 2-р уралдаанд: Юндэнгийн дүрээр Тэргүүн байр

“Морин хуур” уралдааны 1992, 1996, 2010 оны –Тэргүүн байр

“Цагаан лавай” дууны уралдаанд “Сүүдэр цармын цэцэг” дуугаараа Тэргүүн байр

“Хайрын дууны наадам”- Тэргүүн байр

2009 онд МХЗХолбооны тэргүүн дээд шагнал

2009 онд Тэргүүний шилдэг гэр бүл

2009 онд Нийслэлийн тэргүүн дээд одон “Ханьгарьд”

Урлагийн тэнгэр сонины үүсгэн байгуулагч

МУЗГХА Соёл Урлагийн хорооны мэргэжлийн зөвлөлийн гишүүн

Монголын Урлагийн ажилтны хорооны мэргэжлийн зөвлөлийн гишүүн

Монголын Урлагийн ажилтны холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Дууны нийгэмлэгийн тэргүүн

/“Хан хэнтий” уран бүтээлчдийн холбооны тэргүүн/



2010 онд бид өөрийн гэсэн байр, тайзтай болж зохион байгуулах ангийн хамт олон нэмэгдсэнээр одоо 80 ажиллагсадтай томоохон айл болсон.

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2011 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 20 дугаар захирамжаар Улаанбаатар чуулгын барилгын тайзны засал, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл суурилуулах, барилгын засварын хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэнээр Улаанбаатар чуулгын даргын 2011 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 04 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулсан.

Үнэлгээний хороо 2011 оны 05 дугаар сарын 26 –ны хурлын тэмдэглэл дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн Улаанбаатар чуулгын барилгын тайзны засал, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл суурилуулах барилгын засварын ажлын тендерт шаардлага хангасан “Чандмань тал” ХК тус



ажлыг гүйцэтгэсэн байна.



Бид Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, иргэдийн уран сайхны боловсролыг дээшлүүлж, үндэсний болон



сонгодог, орчин үеийн урлагийг түгээн дэлгэрүүлэх, Улаанбаатар хотыг гадаад болон дотооддоо сурталчлах зорилго бүхий мэргэжлийн өндөр түвшний урлагийн байгууллага ба Нийслэл Улаанбаатар хотын харъяа мэргэжлийн урлагийн байгууллага болно. Манай чуулга нь байгуулагдсан цагаасаа эхлэн дотоод, гадаадын олон байгууллагатай хамтын ажиллагаатай ажиллаж ирсэн бөгөөд үндэсний урлагийн тоглолтоо хийж байсан.

### **ХЭТИЙН ТӨЛӨВ**

Олон зуун жилийн тэртээгээс өвлөгдөн ирсэн ардын урлагийн төрөл болох морин хуур, хөөмэй, уртын дууг дэлхийн давцанд сурталчлан, нийгэм, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны болон бизнесийн салбарт тодорхой хувь нэмрээ оруулж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангасан уран бүтээлийг мэргэжлийн өндөр түвшинд хүргэх болно.

### **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

**Үндэсний урлагаа дээдлэн хөгжүүлж, дэлхийд таниулан сурталчлах.** Чуулгын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, олон нийтийг хамруулах зорилгоор хамтарсан болон захилгат төрөл бүрийн урлаг соёлын үйлчилгээг Нийслэлийн хэмжээнд үзүүлнэ. Бие даасан тоглолтуудыг шинэ өвөрмөгц шийдлээр үзэгчдэд хүргэх, дуучид уран бүтээлээрээ тоглолт хийх, өөрсдийн онцлогийг тодотгосон өвөрмөгц шийдлийг гаргах. Мэргэжлийн өндөр түвшинд уран бүтээлээ туурвих, хэрэглэгч болон соёл урлагаас алслагдсан дүүрэг, хороодын хүн амд уран бүтээлээ хүргэх чуулгын урын санд байгаа үндэсний урлагийн уран бүтээлийн судалгааг гарган, үзэгчдийн сонирхолд нийцсэн тоглолтыг хэрэглэгчдэд хүргэх

### **АЛСЫН ХАРАА**

13-р зууны тэртээ бидний өвөг дээдэс мориныхоо хурдаар ертөнцийн талыг эзэлсэн бол, 21-р зууны залуус бид морин хуурынхаа хос чавхдасаар энэ дэлхийг байлдан дагуулъя.

Бид жил бүр өөрийн байгууллагийн үйл ажиллааны төлөвлөгөөндөө Монгол улсын засгийн газрын үндэсний хөтөлбөр “Морин хуур” “Уртын дуу” “Монгол хөөмий” “Монгол биелэгээ” хөтөлбөрүүдийг мөрдлөг болгон хэрэгжүүлэхээр тусган ажилладаг.

### **Уртын дуу**

Монгол ардын дууны өв санд мянг мянган дуу үеэс үе дамжин дуулагдсаар ирсэн байдаг. Үүний дотроос “Уртын дуу” нь аялгууны бүтцийн хувьд өргөн, урт байдаг. Монгол ардын уртын дууг ЮНЕСКО “Хүн төрөлхтөний гайхамшигтай соёлын өв” хэмээн бүртгэн тунхагласан.

### **Хөөмэй**

Энэ ер бусын аялгууг ам, хоолой, цээжний авиагаар гаргадаг.

### **Морин хуур**

Морин хуур хөгжим нь Монгол ардын хөгжмийн зэмсгийн нэг юм. Энэ хөгжмөөр монгол ардын болон дэлхийн сонгодог хөгжмийн бүтээлүүдийг тоглож болдог ба Юнеско- оос морин хуурыг “Хүн төрөлхтөний гайхамшигтай соёлын өв” хэмээн бүртгэн тунхагласан.

### **Бий биелгээ**



Энэ бүжгийн төрөл нь эрт дээр үеэс уламжлагдан ирсэн ба ахуй амьдрал, нутаг нутгийн онцлогоос шалтгаалан янз бүрийн хувцас, өөр өөр хөдөлгөөнтэй байдаг.

### **Уран нугаралт**

Энэ нь циркийн үзүүлбэрийг 5-25 насны охид нугарч үзүүлдэг бөгөөд Монголын уран нугараачид дээд зэргийн уян налархай хөдөлгөөнийг үзүүлдэгээрээ онцлог ба монголын урлагийн нэгэн том төрөл юм.

### **Цам**

Цам нь Буддын шашны бурхдын үйлдэл, үлгэр домгийн утгыг агуулж байдаг ба шашны зан үйлийн үеэр залуу лам нар уран чамин хийцтэй хувцас, баг өмсөж богино хэмжээний үзүүлбэр үзүүлж байжээ. Сүүлийн хэдэн жилд цамыг тайзны урлагт ойртуулан багахан хэсгээс нь гадаад дотоодын жуулчдад үзүүлэх болсон.

### **“Дөрвөн уулын сахиус” бүжиг**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь Богд хан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх гэсэн 4 уулын дунд оршдог бөгөөд энэ уулс нь Хангарьд, Хөх өвгөн, Гахай, Нохой гэсэн сахиусан савдагтай юм. Энэ сахиуснуудыг магтан дуулж, уран тансаг хөдөлгөөнөөр илэрхийлэн бүжиглэж байна.

### **Морин хуурын чуулга**

Морин хуурын чуулга нь 2009 онд шинээр байгуулагдсан. Тус морин хуурын чуулгад 12 морин хуурч, 2 их хуурч, ёочин хөгжимчин, уртын дуучид бүрэлдэхүүнтэй. Мөн морин хуурын чуулгын урын санд Монголын уламжлалт ардын хөгжмөөс гадна, Монголын орчин үеийн мэргэжлийн хөгжмийн зохиолчдын зохиол бүтээлүүдээс тоглодог.

-2008 оны 02 дугаар 08-нд МУ-н Ерөнхийлөгч төрийн түшээдтэй золгох Их Тэнгэр цогцолборт болсон ёслолын ажиллагаанд тус чуулгын үндэсний хөгжимчид оролцсон

-Улаанбаатар Москва хотуудын ах дүүгийн найрамдалт харилцаа тогтоосны 50 жилийн ой

-БНС улсад нийслэл хотоо сурталчилан хамтарч ажиллаа.

- 2008 оны 09 оны дүгээр 05-наас 13-ны хооронд Хөх хотод зохиогдсон Олон улсын ардын урлагийн наадамд амжилттай оролцон “Шилдэг тоглолт алтан морь” шагнал авсан. Энэ мэтчилэн олон томоохон арга хэмжээнүүдэд байнга оролцдог.

Ардын хөгжмийн “Хангарьд” үндэсний хөгжмийн найрал, “Гэрэгэ” хамтлаг, “Хишигтэн” хамтлаг, мэргэжлийн өндөр зэрэглэлийн дуучид, хөөмэйч, уран нугараач, бүжиг дэглээч, найруулагч, багш удирдаач зэрэг 40 гаруй уран бүтээлчид уран бүтээлээ туурвиж байна.

### **“ХАНГАРЬД” үндэсний хөгжмийн найрал товч танилцуулга**

“Хангарьд” үндэсний хөгжмийн найрал \камерный оркестр\ нь 2009 оны Алтан намар хөгжмийн наадамд хөгжмийн зохиолч Д.Цогтсайхан “Жороо морьтон” Р.Бат-Эрдэнэ “Айсуй хүлгийн төвөргөөн” хөгжмийн зохиолуудаар оролцон “Шилдэг бүтээлч хамт олон” шагналаар шагнагдсан ба анхлан Хангарьд хэмээх нэрээр нэрлэгдэн Монгол Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын тайзнаа зарлагдан тоглосон 2009 оны 12 сарын 07-ны энэхүү өдөр Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын “Хангарьд” үндэсний хөгжмийн найрал



үүсэн байгуулагдсан өдөр хэмээн тооцдог билээ. Тус найрал нь одоогоор 25 хөгжимчинтэй, нумт, цохивор, цохилуур, үлээвэр хөгжмийн хэсгүүдээс бүрдэр уран бүтээлээ туурвиж байна.

Дэлхий дахин түргэн хурдацтай даяаршиж, соёл, урлагийн олон төрөл зүйлийг хамгаалах ажил хүчтэй өрнөж буй өнөө цагт монголын эзэнт гүрний төр ёсны уламжлалаас үүдэлтэй монгол үндэсний хөгжмийн найралаа шинэ нөхцөлд сэргээн хөгжүүлж, Ази тивд төдийгүй дэлхий дахинд алдаршсан найрал байгуулах бүх боломжийг бүрдүүлэх зорилт тавин ажиллах нь “Хангарьд” үндэсний хөгжмийн найралын тэргүүн зорилт болно.

**“ХАНГАРЬД” ҮХН-ын бүрэлдэхүүнд**

**“ХАМАГ МОНГОЛ”** үндэсний хөгжмийн хамтлаг,

**“ГЭРЭГЭ”** морин хуурын дөрвөл.

**“ХИШИГТЭН”** үндэсний язгуур урлагын хамтлаг,

**“УРИА”** үлээвэр хөгжмийн тавал гэсэн хамтлагууд ажиллаж байна.Тус найралын хөгжмийн зохиолчоор МУСТА Р.Бат-Эрдэнэ

Удирдаачаар БНХАУ-ын Шанхай хотын хөгжмийн дээд сургуулийг удирдаачийн мэргэжлээр төгссөн МУСТА Р.Ганбат, Казакстан улсын Алма-Ата хотын хөгжмийн дээд сургуулийг багшийн удирдлаган дор хөгжмийн удирдаачийн мэргэжлээр төгссөн МУСТА Д.Нямдаш ажиллаж байгаа төдийгүй, МУ-ын ТХШ, АЖ, Л.Мөрдоржийн нэрэмжит үндэсний хөгжимчдийн улсын уралдааны 3–р байрын шагналт Б.Баасансүрэн, МУ-ын ТХШ, АЖ Г.Жамъяаны нэрэмжит Мэргэжлийн морин хуурчдын уралдааны тусгай байрын шагналт Д.Ганзол, А.Мөнгөн, Өсвөрийн хөгжимчдийн анхдугаар уралдааны тэргүүн байрын шагналт Н.Отгончимэг нарын авъяас билэгт чадварлаг хамт олон ажиллаж байна.

**“ХАМАГ МОНГОЛ”** үндэсний хөгжмийн хамтлаг нь монгол үндэсний хөгжмүүдээс бүрдсэн хамтлаг, бүрэлдэхүүний сонгодог жишиг болох 10 хөгжимчдөөс бүрдэн 2010 онд байгуулагдсан.

Тус хамтлагын бүрэлдэхүүнд ёочин, шударга, ятга, морин хуур, хуучир, их хуур, лимбэ ардын бишгүүр, эвэр бүрээ, цохиур хөгжимчдөөс бүрэлдэнэ.

**“ХИШИГТЭН”** үндэсний язгуур урлагийн хамтлаг нь монгол үндэстэний урлагийн эх оргил болсон язгуур урлагаа дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх сурталчлан таниулах зорилготой байгуулагдсан билээ. Тус хамтлагийн бүрэлдэхүүнд морин хуурч Г.Наранбат, морин хуурч хөөмэйч Б.Бат-Өрнөх, Даваажаргал их хуурч Д.Бойжоо нар уран бүтээлээ туурвидаг билээ.

**“ГЭРЭГЭ” хамтлаг**

Тус чуулгын “Гэрэгэ” хамтлаг нь үндэсний хөгжмийн урлагийг өвлөн хөгжүүлэн, түгээн дэлгэрүүлэн Монгол болон дэлхийн улс орнуудад сурталчилах зориолготой байгуулагдсан.

Морин хуур 1- А.Мөнгөн Ёочин хөгжимчин –Х.Бархүү

Морин хуур 2- И.Тэрбиш Хөөмэйч, Их хуурч –Б.Эрхэмбаяр

Морин хуур 3- Д.Ганзол

Хамтлагийн гишүүд нь Гончигсумлаагийн нэрэмжит Хөгжим бүжгийн Коллеж, Монгол Улсын Соёл урлагийн их сургуулийг тус тус дүүргэсэн.

Тэд Монголдоо төдийгүй гадаадын улс орнуудад ардын урлагаа сурталчилан тоглолтуудад амжилттай оролцсоор байна.

Швецари улсын Берн, Цюрих, Женев хотуудад –Ардын урлагын тоглолт



ӨМӨЗ орны Бугат хот –Ардын урлагийн тоглолт  
ӨМӨЗ орны Хөх хот –Олон улсын ардын урлагийн наадам  
ОХУ-н Санкт Петербург хот –Хааны ордоны музейд  
БНСАУ-н Сөүл Гуанжу хот-Гуанжугийн үндэсний оркестртай хамтарсан тоглолт  
БНСАУ-н Намянжу хот –Монголын Соёлын өдрийн тоглолт  
Япон улсын Нагоя хот –Олон улсын ЕХРО-2005 нээлт  
Францын Парис хотноо зохиогдсон –Ардын урлагийн наадам  
АНУ-н Сетль хот –Ардын урлагийн наадам  
ОХУ-н Москва хот –Улаанбаатарын соёлын өдрүүд  
Бельги улс –Ардын урлагийн наадам

**НУБЧ- н дуу анги нь** мэргэжлийн 10 дуучны бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд үүнд МУГЖ-4 МУСТА-3 уран бүтээлээ туурвиж байна. Чуулгын уран бүтээлчид “Миний Улаанбаатар”, “Дунгаамаа”, “Тохуутай сээтэн сэвгэр”, “Тэнгэрийн зээ”, “Сүүтэй цагаан аялгуу”, “Алгирмаа Сумъяа ноён” гэх мэт томоохон уран бүтээлийг туурвасан ба биз даасан тоглолтыг Улаанбаатар хот болон хөдөөгийн ард түмэндээ хүргэсэн. Турк улсын Анкара, Болгар улсын Софи, Швейцари улсын Берн, Цюрих. Женев, БНХАУ-ын ӨМӨЗ орны Бугат хот, ОХУ-н Санкт Петербург, БНСАУ-н Сөүл Гуанжу, Намьянжу. Япон улсын Нагоя, Токио, Францын Парис, АНУ-н Сан-Франциско гэх мэт орнуудаар айлчлан тоглож Монголын ардын урлагаа сурталчилан таниулж ирсэн билээ.

#### **Уртын дуучин МУГЖ Г.Хонгорзул**

МУГЖ Г.Хонгорзул нь нэрт хөгжимчин Ёоёомагийн “Торгоны зам” олон улсын хамтлаг Монгол улсаа төлөөлөн оролцсон АНУ болон Европд Монгол улсаа төлөөлөн оролцон АНУ болон Европд Монгол улсаа таниулан сурталчилдаг бөгөөд тэрээр дараах томоохон хэмжээний тоглолтуудад оролцож байсан арвин туршлага бүхий өсөх ирээдүйтэй Монголын сор болсон уран бүтээлч юм. Тухайлбал:

2002 онд Япон улсын Токио хотод явагдсан: Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний нээлтэд оролцож, уртын дуугаар нээсэн.

2005 онд Швейцарийн Стокгольм хотноо Нобелийн шагнал гардуулах ёслолыг нээж дуулсан. АНУ –ын Гарнегим халл, Их Британи улсын Алберт халл, Шведийн концепт хаус, ОХУ-н Большой халл, Лос Анжелес хотын Холливудовл зэрэг дэлхийн алдартай театруудын тайзнаа дуулж үндэснийхээ соёлыг сурталчилж байсан.

2004 онд Монгол улсын соёлын тэргүүний ажилтан

2005 онд Монголын эрхэм элч өргөмжлөлт

2007 онд алдарт дуучин С.Дамчаагийн нэрэмжит уртын дуучидын улсын уралдааны 3-р байрны шагнал

2009.03.16-нд Монгол улсын Гавъяат Жүжигчин цолоор тус тус шагнуулсан билээ.

#### **Дуучин МУГЖ С.Ганзориг**

Тэрээр 2002-2006 онд Соёл Урлагийн их сургуулийг мэргэжлийн дуулаачийн мэргэжилээр төгссөн.

2004-2007 онд “Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн чуулга”-д дуулаачаар, 2007 оны 10 сараас Нийслэлийн Улаанбаатар чуулгын дуучнаар орсон ба урын сандаа Монгол ардын богино дуу -30, нийтийн зохиолын 80-иад дуутай. МУСТА С.Ганзориг нь тэмцээн уралдаанд амжилттай оролцсоор ирсэн ба:



2005 онд “Миний эх орон” сэдэвт мэргэжлийн дуулаачдын уралдаан –Тэргүүн байр

2007 онд Монгол ардын богино дуу дуулаачдын улсын уралдаанд 3-р байр

2008 онд Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан, дуучдын улсын анхдугаар уралдаан 3-р байрыг тус тус эзэлж байсан.

2009.12.02 онд Монгол Улсын Гавъяат жүжигчин цолоор шагнагдсан билээ.

Монголын ард түмний хайртай дуучин бөгөөд цаашид олон уран бүтээлээрээ та биднийг сэтгэлийг хөглөх бизээ.

#### **Дуучин МУГЖ Т.Баяраа**

Тэрээр 1974 онд гимнастикийн спортын мастер тамирчин

1983 онд Тэргүүний сэхээтэн Алтан мядаль

1986 онд Арын богино дуу дуулаачдын улсын уралдаан Тэргүүн байр

Соёлын яамны жуух

1995 онд МУСТА цол тэмдэг

Засгийн газрын жуух

Хөдөлмөрийн хүндэт мядаль

1997 онд ардын хошин шог дуулаачдын улсын уралдааны Тэргүүн байр

2000 онд Алтан гадас одон

2011 он ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль

2011 оны 12 сарын 30 нд МУГЖ цол тэмдэгээр шагнагдсан.

#### **Дуучин МУГЖ Д.Ширмэнтуяа**

1998 онд Тэргүүний залуу алтан медаль

2000 онд МУСТА

Их Монгол улс байгуулагдсаны 80 жилийн ойн медаль

Алтан гадас одон

1990 онд Хүүхнүүд ардын дууны хит парадад дэд байр

1990 онд Вьетнам дуу дуулаачдын тэмцээнд тэргүүн байр

1993 онд Морин хуур улсын уралдаанд тэргүүн байр

2009 онд Гавъяатын гараа уралдаанд тэргүүн байр

2010 онд Морин хуур уралдаанд шагналт байр

2011 оны 12 сарын 29 нд МУГЖ цол тэмдэгээр шагнагдсан билээ.

#### **НУБЧ-н Айлчлан тоглосон орнууд:**

ОХУ, Швецарь, ӨМӨЗО, БНСУ, БНУУ, БНХАУ, Япон, Франц, АНУ, Араб, Бельги Швейд, Вьетнам, Комбож, Лаос, Энэтхэг, Тайвань, Польш, Болгар, Чех, Герман, Румын, Англи, Испани, Куба, Афганистан, Пакистан, Алжир, Канад, Казакстан, Итали, Австри, Австрали, Голланд, БНАСАУ, Азербайджан, Киргиз, Узбек, зэрэг орнуудад айлчлан тоглосон.

#### **НУБЧ-н авсан гавъяа шагнал:**

2008-07.14 Их монгол улс байгуулагдсаны 802 үндэсний баяр наадмын 87 жилийн ойн Төрийн хүндэтгэлийн концерт баяр наадмын нээлт ажиллагаанд идэвхтэй оролцсонд талархаж Өргөмжлөл гардав.

2008- Шилдэг бүтээл НУБЧ-н 21-р зуун бүтээл

2008-12.24 Өргөмжлөл 2008 оны шилдэг оюуны хөрөнгө оруулагч байгууллага

2008 он ӨМӨЗО олон улсын ардын урлагийн их наадам шилдэг бүтээлийн

“Хөх морь” шагнал

2008 он ӨМӨЗО Хөх хотын даргын Дурсамж



2008 он БНСАУ-н “Каннам Дейнс” мэргэжлийн бүжигчдын их наадам Сөүл хотын даргын дурсамж  
2008 он БНСАУ-н “Каннам Дейнс” мэргэжлийн бүжигчдын их наадам 4-р байрын шагнал  
2009-04.09 Дурсамж  
2009-05.30 Талархал /Бадамлянхуа халамжийн төвийн захиргаа/  
2009-03.05 Өргөмжлөл /407-р ангийн хүмүүжигчид/  
2009-10.29 Батламж Дөрвөн хайрханаа дээдлэн шүтэе Сэтгэлийн өргөл аян  
2009-10.29 Монгол улсын Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн ой угтсан ажилд идэвх зүтгэл гарган хотын хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр үзүүлсэн тул Хүндэт өргөмжлөл  
2009-10.14 НУБЧ-н хамт олонд Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн Хүндэт өргөмжлөл  
2009-12.07 Алтан намар-2009 наадмын шилдэг бүтээлч хамт олноор тодруулан хүндэт өргөмжлөл  
2010 ӨМӨЗО Зиаушин хатны нэрэмжит дурсамж  
2010-06.24 Хүндэт өргөмжлөл  
2010 он Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Хүндэт өргөмжлөл”  
2010-11.04 “Хүндэт өргөмжлөл” Хүүхдийн жүжгийн улсын анхдугаар уралдаан зохион байгуулахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажилласанд талархаж.  
2010-10.23 “Талархал” /Монголын Лектор төвөөс/  
2010-10.23 Хүндэт өргөмжлөл /Улаанбаатар эрдэм оюу дээд сургууль/  
2010-11.20 Батламж /Монголын улаан загалмайн нийгэмлэг/  
2010-06.01 Талархал  
2010-12.04 Шилжин явах цом  
2010.12.04 Хүндэт өргөмжлөл  
2011 он Талархал /Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч/  
2011-06.10 Талархал /Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч  
2011-07.09 Хүндэт өргөмжлөл /Ардын хувьсгалын 90 жил сум байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан/  
2011-03.21 Хүндэт өргөмжлөл  
2011-03.20 Дурсгал /Баян өлгий аймгийн засаг даргын тамгын газар

**2006 онд НУБЧ-ын хийсэн ажил**

**2006.10.27** СТӨ: Нийслэлийн 367 жилийн ойн хүндэтгэлийн концерт найруулан тоглож 160 гаруй уран бүтээлчид оролцов.  
**2006.12.02** СТӨ: Дуун түрлэгтэй “Хан Хэнтий нутгийнхан” концерт найруулан тоглолоо 150 гаруй уран бүтээлчид оролцов.  
**2006.12.10** СТӨ: “НУБЧ-ын нээлтийн концерт”-нд нийслэлийн бүх мэргэжлийн урлагийн байгууллагаас 270 орчим уран бүтээлчид оролцон баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд 1000 гаруй үзэгчид ирж үзэж сонирхсон байна.  
**2006.12.31** Сүхбаатарын талбай: “Их Монголын мөнгөн шөнө” бүх нийтийн цэнгүүнийг зохион байгууллаа. Уг цэнгүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, МУ-ын Ерөнхий сайд, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны дарга М.Энхболд,





Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж, МУ-ын сайд ЗГХЭГ-ын дарга С.Батболд, НИТХТ-ийн дарга Н.Болормаа, НЗД бөгөөд УБ хотын захирагч Ц.Батбаяр болон албаны бусад хүмүүс оролцсон. 90 орчим уран бүтээлчид дуулж бүжиглэн 5000 хүн энэ баярыг ирж үзэн, олон хүн хамарсан томоохон ажил боллоо.

#### **НУБЧ-ын 2007 онд хийсэн ажил**

**2007.01.23** ХЗСТөвд: “Багш та” нийслэлийн 150 гаруй багш нарын урлагийн үзлэгийг зохион байгуулснаас 32 багш шалгарлаа.

**2007.01.26** СТӨ: “Хороодын хөгжлийг дэмжих жил”-ийн ажлыг дүгнэх, “Ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх жил”-ийн нээлтийн ёслолын ажиллагааны концерт 120 орчим хүний бүрэлдэхүүнтэй болж өнгөрлөө.

**2007.02.02** СТӨ: Нийслэлийн багш нарын баярын өдөрт зориулсан “Багш та” хүндэтгэлийн концертонд 120 гаруй хүн оролцов.

**2007.03.03** СБ талбай: “Их Хаанд хүндэтгэл үзүүлэх ёслол” /шинийн 15/-ын ажиллагааг 250 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан.

**2007.03.19** СБ талбай: “Тэмээн поло Өвлийн фестиваль-2007” наадмын хаалтын ажиллагааг зохион байгуулсан.

**2007.04.13** Их тэнгэр цогцолбор: “УБ-ын хөгжил – Гадаад харилцаа” сэдэвт өдөрлөг

**2007.05.08** СТӨ: МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохиогдох Нийслэл УБ хотын “Нэг сая дахь иргэн – Үндэсний бахархал” хүндэтгэлийн ажиллагааг 130-аад хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.

**2007.06.01** СБ талбай: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Нийслэлийн хүүхдүүд” баярын нэгдсэн арга хэмжээг 400-гаад хүний оролцоотойгоор зохион байгуулж, 3000 хүүхэд аав, ээжтэйгээ үзэж баярлалаа.

**2007.06.16** Жаргалант тосгон: “Шинэ зууны нийслэлчүүд” аяны хүрээнд нийслэлийн соёл, урлагийн газар, харъяа байгууллагуудаас зохион байгуулсан арга хэмжээнд 60-аад хүний бүрэлдэхүүнтэй очиж оролцлоо.

**2007.10.24-28** Улаанбаатар – Москва хоёр хотуудын хамтын ажиллагааны 50 жилийн ойн хүрээнд нийслэл Улаанбаатар хотноо айлчлах Москва хотын урлагийн төлөөлөгчдийг хүлээн авч үйлчиллээ

**2007.10.25** РЦНК: “Улаанбаатар-Москва” шилдэг идэвхитэнүүдэд шагнал гардуулах ёслол, баярын концерт.

**2007.10.26** МҮЭСТО: Улаанбаатар – Москва хоёр хотуудын хамтын ажиллагааны 50 жилийн ойн баярт зориулсан концерт.

**2007.10.28** СТӨ: Нийслэлийн 368 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн концертыг 120 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж хийлээ,

**2007.11.08-11** Москва: “Улаанбаатар” хотын соёлын өдрүүд”-д 36 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

**2007.11.09** Павел Слободкины заал: Хоёр хотын мэр болон албаны төлөөлөгчид, ард иргэд

**2007.12.07** Эрдэнэт хот, “Хангарьд” спорт цогцолбор: 20 хүнтэй тоглолт хийлээ,

**2007.12.27** Баянгол ресторан: МҮХАҮТ-ын шилдэг 100 аж ахуйн нэгж шалгаруулах “Интерпринер-2007” меркюри шагнал гардуулах ёслолын ажиллагааны урлагийн хэсгийг хариуцан ажиллаа. 40 орчим уран бүтээлчид оролцсон.

**2007.12.30** Брай Хаус: “Жи-мобайл” компанийн шинэ жилийн цэнгүүний баярыг зохион байгуулсан.

#### **НУБЧ-ын 2008 онд хийсэн ажил**



- 2008.01.18** СУИС: “Гэрэгэ” хамтлагийн 5 хөгжимчний тайлбарт концерт.  
**2008.02.01** УБ Палас: Монголын багш нарын өдөрт зориулсан “Багш танаа” хүндэтгэл ёслолын ажиллагаа  
**2008.04.08** МХО: Дэлхийн эрүүл мэндийн өдөрт зориулсан ЧД-ийн ЭМБ-дын эмч сувилагч, эмнэлгийн мэргэжилтний уулзалт өдөрлөгийн урлагийн хэсгийг зохион байгууллаа.  
**2008.04.12** СТӨ: “21-р зуун” тоглолт.  
**2008.04.13** СТӨ: “21-р зуун” тоглолт  
**2008.04.16** Сэлэнгэ аймаг Хүдэр сум  
**2008.04.27** СТӨ: Нийслэлийн Хувьсгалт Намын хорооны 83 жилийн ойд зориулсан концертыг **240** хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж  
**2008.05.02** МБӨ: Олон улсын сувилагч нарын баярын өдөрт зориулсан тоглолт  
**2008.05.14-16** “Улаан-Үд хотын эдийн засаг, соёлын өдрүүд”-д оролцох урлагийн төлөөлөгчдөд үйлчиллээ.  
**2008.05.15** СБ-ын талбай: театрчилсан тоглолт.  
**2008.05.15** СТӨ: “УБ-Улаан-Үд” үзэсгэлэн яармагийн нээлт.  
**2008.05.15** СТӨ: “Улаан-Үд хотын эдийн засаг, соёлын өдрүүд”-н нээлтийн концер




- 2008.05.16** СТӨ: иргэдэд зориулсан концерт.  
**2008.05.16** НХЗГ: иргэдэд зориулсан концерт.  
**2008.05.16** СТӨ: “Улаан-Үд хотын эдийн засаг, соёлын өдрүүд”-н хаалтын “Найрамдал” хамтарсан концертод **250** гаруй жүжигчид оролцсон бөгөөд соёлын өдрүүдийн хүрээнд зохиогдсон  
**2008.05.16** Баянгол ресторан: Улаан-Үд хотын дарга Г.А.Айдаевын хүлээн авалт.  
**2008.06.12** СТӨ: “Иргэдэд ажлаа сурталчилах өдөр”-ийн тоглолт.  
**2008.07.08** СБ-ын талбай: “Дээлтэй Монгол” аялал жуулчлалын нээлттэй өдөрлөг.  
**2008.07.25** Тэрэлж: “Америкийн үндэсний газар зүйн нийгэмлэг” -ийн зочдоод зориулсан бага наадмын ажиллагааг зохион байгууллаа.  
**2008.08.08** “Бишрэлт” ресторан: Японы жуулчдад зориулсан тоглолт.  
**2008.08.25** СБ-ын талбай: Зуны Олимпийн 29 дэх удаагийн наадамд оролцсон Монголын баг тамирчдыг хүндэтгэн угтах нийслэлчүүдийн үдшийн цэнгүүний урлагийн тоглолт  
**2008.09.03-13** Хөх хот: ОУ-ын ардын урлагийн наадам Уг наадмаас “Шилдэг тоглолт” алтан морь шагналыг эх орондоо авч ирсэн бөлгөө.  
**2008.09.16** УБ Палас: НЗД бөгөөд УБ хотын захирагч Билэгт, “Сод Монгол” группийн ерөнхийлөгч Анандбазар нар СХД-ийн иргэдтэй хийсэн уулзалтын урлагийн тоглолт  
**2008.09.24** СТӨ: Хотын ерөнхий менежер Г.Мөнхбаяр ЧД-ийн ахмадуудтай хийсэн уулзалтын урлагийн тоглолт



- 2008.10.02** Мишээл экспо: “Намрын халуун өдрүүд”-ийн нээлт  
**2008.10.04** Хаадын өргөө: БНСУ-ын болон Хөх хотын Мөрөн зэрэг  
**2008.10.06** Дисковери Монголиа: Монголын Авто замчдын Ахмадын хорооны 20 жилийн ойн тоглолт  
2008.10.08 СТӨ: “Соёлтой иргэн-Эрүүл орчин” өдөрлөгт зориулсан тоглолт  
**2008.10.16** УБ ресторан: Зүүн хойд Азийн аялал жуулчлалын О/У-ын 5-р чуулганы зочдод зориулсан УБ хотын захирагчийн хүндэтгэлийн хүлээн авалт  
**2008.10.18** Бишрэлт ресторан: тоглолт  
**2008.10.28** СТӨ: Нийслэлийн 369 жилийн ойн хүндэтгэлийн концерт  
**2008.11.21** МБӨ: С.Ганзоригийн бие даасан “Миний УБ” тоглолт  
**2008.12.13** “Эргэн дурсахуй” төв: БГД-ийн худалдааны ажилчдын өдөрлөгт зориулсан тоглолт  
**2008.12.19** “Их Тэнгэр” цогцолбор: Нийслэлийн соёл урлагийн салбарын өдөрлөгт оролцлоо.  
**2008.12.24** Сүнжингранд: НИТХ-ын шинэ жилийн цэнгүүний ажиллагаа  
**2008.12.27** УБ Палас: БГД шилдгүүддээ шагнал гардуулах ёслолын ажиллагаа  
**2008.12.31** СБ-ын талбай: Нийслэл хот байгуулагдсаны 370 жилийн ойн нээлтийн үйл ажиллагаанд зориулсан урлагийн арга хэмжээ
- НУБЧ-ын 2009 онд хийсэн ажил**
- 2009.03.14** УБ Палас: МАХН-аас НИТХ болон дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчид СХД-ийн иргэд, сонгогчидтой уулзалт хийж, 20 хүний бүрэлдэхүүнтэй урлагийн тоглолт. хөтөлбөрийн хүрээнд 21 уран бүтээлчид тоглолт  
**2009.03.20** Мэдээлэл Технологийн Парк: “Шар хантаазтан” зам талбайн  
**2009.03.17** ХЦДС: Дэд үйлчлэгч нарын 2-р зөвлөгөөний төлөөлөгчдөд зориулсан тоглолт  
**2009.04.08** “Хан Хэнтий” чуулга: 30 хүний бүрэлдэхүүнтэй тоглолт  
**2009.04.09** Хэнтий Баянхутаг сумын клуб  
**2009.04.18** Улсын Цирк: “Монголын тэнгэрийн элчүүд” тоглолт, Хавайн аралд ажиллаж байсан УЦ-ийн агаарын жүжигчид авто осолд орон, эмчилгээний зардалд нэмэрлэх хандив цуглуулах тоглолтыг ар гэрийнхэнтэй нь хамт зохион байгуулж хамтарч ажиллав, манай дуучид оролцсон.  
**2009.04.21-25** МУ-ын Хөдөлмөрийн баатар, АЖ, ТШ Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны уралдаанд оролцохоор ирж байгаа Буриадын Улаан-Үд хотын 5-р сургуулийн “АКВАРЕЛЬ” найрал дууны.  
**2009.04.24** МХО: МУ-ын Хөдөлмөрийн баатар, АЖ, ТШ Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны хамтарсан ГАЛА тоглолт.  
**2009.04.30** СТӨ: Ус сувгийн удирдах газрын 50 жилд зориулсан “Хатан Туулын эгшиглэн” тоглолтыг манай 30 хүний оролцоотой хийж 800 хүн үзлээ. Нийслэлийн “Улаанбаатар” чуулга Нийслэлийн 370 жилийн ойдоо



#### Хэвлэл мэдээлэл



Сонин	42
Телевиз	68
Сайт	5
FM	748
Нийт	863

#### 2010 оны үйл ажиллагаа

##### Шинээр санаачилсан ажил

##### “Соёлтой хот, соёлтой иргэн” аян 1

Агуулга: МУ-ын ЗГ-аас соёл урлагийн салбарт хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Зорилго: Нийслэл хотынхоо өнгө үзэмжийг цэвэр цэмцгэр байлгахын төлөө цаг наргүй ажилладаг ТҮК-ний нийт шар хантаазтангууддаа ая дууны цэнхэр хадгаар бэлэг барьж сэтгэлийн дэм өгч, эд материалын туслалцаа үзүүлсэн.

Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга /ая дуугаар сэтгэлийн бэлэг барих/

Хамтран зохион байгуулагч: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой/

Нийслэлийн улаан загалмайн нийгэмлэг /50 хүний хувцас хандивлах/

Иргэн Б.Батжаргал /300 гутал хандивлах/

Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын концертын Их танхим

2010 оны 05 сарын 7-ны өдрийн 17:00 цагт

Хамрагдах хүрээ: ТҮК-ний 215 ажилчин

Үр дүн: Тэдний сэтгэлийн болон ажлын алжаал хэсэг хугацаанд тайлагдана.

##### “Соёлтой хот, соёлтой иргэн” аян 2

Зорилго: НУБЧ-ын ажилтан албан хаагч, уран бүтээлчид мөн түрээслэгчид дундаа архи тамхигүй орчин аяныг 2010 оны 05 сарын 01-нээс эхлэн зарласан билээ.



**Үр дүн:** Энэхүү аян нь гадна дотны хэрэглэгчдээс өндөр үнэлгээ авсан ба чуулгын байранд эмх цэгцтэй орчин бий болж ажлын таатай орчин бүрдэж чадсан.

### “ХҮҮХЭД БИДНИЙ ИРЭЭДҮЙ” АЯН 1

“Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе” уриан дор тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион явуулах “Жаахан цэрэг” хүүхдийн урлагийн анхдугаар наадам.

**Зорилго:** Эх орны ирээдүй залгамж, хойч, өсвөр үеийнхний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тэдэнд өөрийгөө хөгжүүлэх боломж олгох, хүүхдийн авъяас билгийг хөхүүлэн дэмжих, эх орон, онгон байгалиа хайрлан хамгаалах, ард түмнийхээ ёс заншил, урлаг, соёлыг уламжлан өвлүүлэх, эцэг эх, ахмад үеэ эрхэмлэн дээдлэн хүндэтгэх, эх оронч үзэл төлөвшүүлэх.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлснээр хүүхдэд хандах харилцааны шинэ хандлага бий болгож, хүүхдийн оролцоо, хөгжил, хүмүүжил, амралт, чөлөөт цагийн зүй зохистой үйл ажиллагааны үр дүнд нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, өөрийгөө илэрхийлэх чадвартай, эх оронч үзэлтэй, ирээдүйдээ итгэл, үнэмшилтэй шинэ иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, хүүхэд, өсвөр үеийхэнд эцэг, эхийнхээ ажил, мэргэжлээр бахархах сэтгэл төрүүлж, хүүхдийн наадмын үйл ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Хүүхдийн урлагийн наадмыг УАБ-ыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын хүүхдүүдийн дунд зохион явууллаа. 2010 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд 3 үе шаттай явагдсан.

**Үр дүн:** Хүүхдийн их наадмыг 06-16 насны хүүхдүүдийн дунд дуу, хөгжим, бүжиг, язгуур урлаг, уран уншлагын төрлүүдээр зохион явуулж авъяасыг нээж, урам зориг хайрлах.

### “ХҮҮХЭД БИДНИЙ ИРЭЭДҮЙ” АЯН 2

“Халзан тавхай” хошин шог уралдаан

**Зорилго:** Суралцагсдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хошин шог урлагийг сурталчлах, тэдний авъяас чадварыг илрүүлэн хөгжүүлэх.

**Болзол:** Гадаад дотоодын уран зохиол, ардын аман дэгс ярианууд, хошин урлагийн мастеруудын бүтээл, өөрсдийн зохиомжит элэглэл зэргээр бэлтгэсэн байх ба хүүхдэд дөхүү сэдэв сонгох.

Тоглолт нь сэдэв, зохиомж, ур чадварын хувьд зохистой сайн бэлтгэгдсэн байх ба зөвхөн хүүхэд багачуудын тухай өгүүлнэ.

#### “Халуун сэтгэл” аян 1

**Зорилго:** Бид нийгмийн тодорхой сигментэд хандан урлагийн тоглолтоо үнэ төлбөргүй тоглодог бөгөөд соёл урлагийн үйлчилгээ тэр бүр очдоггүй алслагдсан дүүрэг, хороод, иргэд, хүүхэд, ахмадууд, эмэгтэйчүүдээ сонгон очиж чуулгынхаа урийн сангийн дээжээр ая дууны мэндчилгээ хүргэж тэдгээр хүмүүстээ сэтгэл санааны, эд материалын дэмжлэг туслалцааг үзүүлэхэд оршино.

**Төлөвлөгөө:** Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга Батсүмбэр дэх ахмадын “Улсын Асрамжийн газар”

2010 оны 02 сарын 10-ны өдрийн 11:00 цагт



### Хэвлэл мэдээлэл

Сонин

“Нийгмийн толь” сонин ( 2010.02.11-ний дугаарт гарсан )

“Үнэн” сонин ( 2010.02.11-ний дугаарт гарсан )

“Улаанбаатар таймс” сонин ( 2010.02.09-ний дугаарт гарсан)

Телевиз

МҮОНРТ “ММ” агентлагын мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

UBS “City news” мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

b tv телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

Үр дүн: Иргэдийн урлаг соёлын мэдэгдэхүүн дээшилж, соёлын үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

### “Халуун сэтгэл” аян 2

Зорилго: “Мартын 8 буюу Олон Улсын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдөр”-өөр ШШГЕГ-ын 407-р ангийн хүмүүжигч бүсгүйчүүдэд сэтгэлийн дэм хайрлах. Ардын болон эстрадын дуугаар ая дууны сүүн цагаан цацал өргөх, Эмэгтэйчүүдийн болон хүүхдийн хувцас, шүдний оо сойз, саван хандивлах, Шүдний эмч эмэгтэйчүүдийн шүдийг эмчлэх.

Төлөвлөгөө: Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга

Хамтран зохион байгуулагч: Нийслэлийн Улаан Загалмайн нийгэмлэг ШШГЕГ-ын 407-р анги Хамрагдах хүмүүсийн тоо: 333 эмэгтэйчүүд

Тоглолтонд: МУГЖ Г.Хонгорзул, МУСТА С.Оюунчулуун, М.Анхтуяа, Т.Баяраа болон дуучин Г.Ганбат, С.Отгонбаатар нар эхийн ба бүсгүйчүүдийн сэдэвтэй дуугаар ая барьсан.

“Хангарьд” үндэсний хөгжмийн “Гэрэгэ” хамтлагууд хөгжимдсэн.

Найруулагч МУСТА П.Урнаа, менежер Ц.Оюунсүрэн, тоннмейстр Ц.Гангантөгс нар үйл ажиллагааг зохион байгууллаа.

### Хэвлэл мэдээлэл

Сонин

“Нийгмийн толь” сонин /2010.03.05 болон 09-ний дугаарт гарсан/

“Үнэн” сонин /2010.03.005-ны дугаарт гарсан/

“Өнөөдөр” сонин /2010.03.05-ны дугаарт гарсан/

Телевиз

UBS телевизийн “City news” мэдээллийн хөтөлбөрийн үгэн мэдээгээр гарсан.

Үр дүн: Соёл урлагаас алслагдсан 333 гаруй эмэгтэйчүүдээ сэтгэлийн дэм хайрлаж урлагийн гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх.

### “Халуун сэтгэл” аян 3

Зорилго: Цэргийн баярт зориулан зэвсэгт хүчний 032-р ангийн офицер, ахлагч, цэргүүдэд ая дууны мэндчилгээ хүргэх.

Төлөвлөгөө: Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга

Зэвсэгт хүчний 032-р анги 2010 оны 03 сарын 12-ны өдөр

Тоглолтонд: МУГЖ С.Ганзориг, Г.Хонгорзул, МУСТА М.Анхтуяа, Д.Баасанжав, Т.Баяраа, дуучин Г.Ганбат, Д.Дагиймаа, С.Отгонбаатар нар эх орон, цэргийн сэдэвтэй дуу дуулж, бүжигчин С.Тунгаа монгол ардын бүжиг бүжиглэсэн.

Найруулагч МУСТА П.Урнаа, тоннмейстр Ц.Гангантөгс нар үйл ажиллагааг зохион байгуулсан.

Үр дүн: Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ардын ба орчин үеийн урлагийг сурталчлах.



#### “Халуун сэтгэл” аян 4

Зорилго: “Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдөр”-өөр хүүхэд тэр дундаа эцэг эхийн хайр халамжийг үгүйлэн суугаа алдрай бяцхан хүүхэд багачуудаа баярлуулна.

Төлөвлөгөө: Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга  
Хамтран зохион байгуулагч: Мацаг хоол Энх-амгалан ТББ 5-р сарын 30-ны өдөр

Нийслэлийн “Улаанбаатар” чуулгын Их танхимд Хүүхдийн жүжгийн мюзикл үзүүлэх. “Царцаа Намжил”, “Улаан малгайт”, “Манжин” мюзикл Хүүхдийн зургын үзэсгэлэн, Үлгэрийн баатруудтай зураг авхуулах

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвд сурч хүмүүжиж амьдардаг 170 хүүхэд “Бадамлянхуа” хүүхдийн төв 108-н хүүхэд багачуудад

#### Хэвлэл мэдээлэл

“Үнэн” сонин / 2010оны 5 сарын 31-ний дугаарт гарсан /

“Нийгмийн толь” сонин / 2010оны 5 сарын 31-ний дугаарт гарсан /

“Өнөөдөр” сонин /2010оны 5 сарын 31-ний дугаарт гарсан/

“Монголын мэдээ” сонин /2010оны 5 сарын 31-ний дугаарт гарсан/

“Монголын нэг өдөр” сонин /2010 оны 6 сарын 04-ний дугаарт гарсан/

#### Телевиз

МҮОНРТ “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

“UBS” телевизийн “CITY NEWS” мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

Боловсрол сувгийн хүүхдийн баярын нэвтрүүлгээр гарсан.

Tv 8 телевизийн “Толь” мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

ТМ телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр гарсан.

**Үр дүн:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр мөн нийслэлийн дэд хөтөлбөрийн хүрээнд тусгагдсаны дагуу хүүхдийг нийгэмшүүлэх, соёл урлагаас алслагдсан хүүхдийн урлагийн ойлголт, мэдрэмжийг сайжруулах, өвлүүлэх. “Монгол үндэсний урлаг бидний бахархал” жуулчдад зориулсан тоглолт.

Зорилго: Монгол үндэсний урлагаа гадаадын жуулчид болон аялагчдад сурталчлах хамтын харилцааг тогтоох.

Ерөнхий зохион байгуулагч: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга

Хамтран зохион байгуулагч: “Гэгээн тал” жуулчны бааз

2010 оны 07 сарын 17-27 өдрүүдэд

Хөх хотын “Гэгээн тал” жуулчны баазад

**Үр дүн:** Гадаадын жуулчдад урлагийн тоглолтоо мэргэжлийн түвшинд хүргэх, монгол ахуй, ёс заншил, үндэсний урлагаа сурталчлах, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хөх хот дахь ардын урлагийн 7-р наадам

**Зорилго:** Уг наадамд чуулгаа болон монголын ардын урлаг тэр дундаа уртын дуу, морин хуурыг түлхүү сурталчлах.

Ерөнхий зохион байгуулагч: Хөх хотын соёлын газар,НЗДТГ

Хамтран зохион байгуулагч:Нийслэлийн соёл урлагийн газар,“Нийслэлийн “Улаанбаатар” чуулга

2010 оны 07 сарын 10 -17 өдрүүдэд, Хөх хотод



**Үр дүн:** НУБЧ нь уг наадамд амжилттай оролцож “Шилдэг тоглолт” шагналыг хүртсэн.

Ширээт цагаан нуурын гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүллээ.

Зорилго: Нийслэлийн анхны шав тавьсан газар болох Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг дахь “Ширээт цагаан нуурын Гэрэлт хөшөө”-нд нийслэлийн 371 жилийн ойг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаанд НУБЧуулга оролцлоо.

Ерөнхий зохион байгуулагч: НЗДТГ, Нийслэлийн хэвлэл мэдээллийн газар  
Хамтран зохион байгуулсан: НСУГ ,НУБЧ

**Үр дүн:** Жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа энэхүү ажиллагаанд нийслэлийн харьяа газрууд болон Өвөрхангайчууд өргөнөөр оролцож нийслэлийн анхны шав тавьсан газартаа хүндэтгэл үзүүллээ.

Бидний шинээр санаачилсан ажил

Нийслэлийн “Улаанбаатар” чуулга нь Монгол Улсын Нийслэлийн 370-н жилийн ой, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2009-н оны зорилтод тусгагдсан: Нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүрээг өргөтгөн, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Сэтгэлийн Өргөл” аянаа 2009.02.10-наас эхлэн шинээр санаачилан зохион байгуулж байгаа юм.

### “Сэтгэлийн Өргөл” аян

Батсүмбэрийн асрамжийн газар

407-р анги

Хилийн цэргийн дээд сургууль



Шар хантаазтан



Бадамлянхуа хүүхдийн төв



FM радио






Зорилго: Бид нийгмийн тодорхой сигментэд хандан урлагийн тоглолтоо үнэ төлбөргүй тоглодог бөгөөд соёл урлагийн үйлчилгээ тэр бүр очдоггүй алслагдсан дүүрэг, хороод, иргэд, хүүхэд, ахмадууд, эмэгтэйчүүдээ сонгон очиж “Улаанбаатар” чуулгын урийн сангийн дээжээр ая дууны мэндчилгээ хүргэж тэдгээр хүмүүстээ сэтгэл санааны, эд материалын дэмжлэг тусалцааг үзүүлэхэд оршино.





**“Сэтгэлийн Өргөл” аянд хамрагдсан иргэдийн статистик график:**





**“Дөрвөн хайрханаа дээдлэн шүтэе”**

Агуулга: Нийслэлийн “Улаанбаатар” чуулга нь Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойн баярын хүрээнд мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2009-2012 оны үйл ажилгааны хөтөлбөрийн дагуу “Дөрвөн хайрханаа дээдлэн шүтэе” танин мэдэхүйн тойрон аялалаа Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн тамгын газартай хамтран зохион байгуулсан билээ.

